



“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 7-р сарын 01 өдөр

Дугаар: 22/01/05, Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 61 дугаар зүйл, 61.9 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.2, 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 8-р сарын 11-ний өдрийн 09 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Жуулчны гудамж, Монгол Тайваны төвийн 2-р давхарт 207 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 7-р сарын 22-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Нэмэлт хувьцаа гаргах, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
 2. Компанийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулах
 3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах
 4. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай
 5. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2022 оны 7 дугаар сарын 06-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2022 оны 7-р сарын 22-нд уг зарыг давтан, 2022 оны 7-р сарын 11-ний дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 8-р сарын 22-ны өдрийн 09 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.

7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2022 оны 7-р сарын 18 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /У.Анар/-т даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Гүйцэтгэх Захирал У.Анар, гишүүнээр Брокер Л. Дөлгөөн, Тооллогын комиссийн даргаар У.Ангараг, гишүүнээр А.Амирлан нарыг тус тус томилсугай.
10. “Блюскай секьюритиз УЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ОЮУНБОЛД